

## **Австралид суралцах боломж**

Австрали нь англи хэлтэй цөөхөн баян улсын нэг. Хүн болгонд олдоод байдаггүй, австраличууд өөрсдөө ч хөдөлмөрлөөд олж авч чаддаггүй сургалтын тэтгэлгийг Монголчууд бидэнд Австралийн Засгийн газраас олгож байна. AUSAID хэмээн нэрлэж заншсан байгууллага нь Австралийн Засгийн газрын Олон улсын хөгжлийн агентлаг билээ.

Австралийн Засгийн газар жил бүр бүс нутгийн хөрш орнууддаа AUSAID-ээр дамжуулан оюуны хөрөнгө оруулалт хийдэг. Монгол хүн Та ADS (Australian development scholarship) буюу Австралийн хөгжлийн тэтгэлэг, ALA (Australian Leadership Awards Fellowships) буюу Австралийн манлайлагчийн тэтгэлэг авах боломжтой.

### **ADS**

Нэр бүхий буурай хөгжилтэй орны иргэдэд өөрийн орны нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулах боловсон хүчин болоход нь Австралид улсад суралцуулах ADS тэтгэлэг олгодог билээ. ADS тэтгэлгээр жил бүр 31 орны 1000 хүртэлх оюутнууд бакалавр, магистр, докторын зэрэгт суралцдаг бөгөөд хүсвэл тухайн оюутан алсын зайн сургалтын хэлбэрийг сонгож болно.

Монголын хувьд магистрын зэрэгт (master by coursework) суралцуулахыг эн тэргүүнд тавьдаг. 2003 оноос эхлэн нэр заасан төрийн байгууллагын 14 хүнд тэтгэлэг олгож байсан бол, 2008 онд 19 хүнд, 2009 онд 24 хүнд тус тус олгосон юм.

Дашрамд дурдахад энэ жилээс анх удаа зөвхөн төрийн албан хаагчид бус, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын ажиллагсад энэхүү тэтгэлэгт хамрагдах боломжтой болж байна. Тэтгэлэгт тавьдаг гол шаардлага нь хүсэлт гаргагч өргөдөл бөглөх үедээ өөрийн байгууллагад хоёроос доошгүй жил тасралтгүй ажилласан, ажлын туршлагатай, бакалаврын зэрэг эзэмшсэн. Австралид төгссөний дараа нэр дэвшүүлсэн байгууллагад 2-оос доошгүй жил ажиллах хүсэлтэй байх, IELTS-ийн 5.0 буюу түүнээс дээш оноотой тэнцэхүйц англи хэлний мэдлэгтэй байх зэрэг ордог.

Та Австралийн их сургуульд суралцахад IELTS-ийн 6.5 ба түүнээс дээш оноо (яриа, бичиг, унших, сонсох чадвар тус бүр наад зах нь 6.0) хэрэгтэй.

Хэлний түвшингийн хувьд танд одоогоор Австралийн их сургуульд суралцах хэмжээний англи хэлний мэдлэг байхгүй (гэхдээ дор хаяж IELTS-ийн 5.0 байх) боловч таны өргөдөл шалгарах юм бол танд есөн сарын англи хэлний курст Монголд үнэгүй сурах боломж олгоно. Есөн сарын дараа дахин IELTS -ийн шалгалт өгч, австралийн их дээд сургуулиудад ороход шаардагдах IELTS-ийн 6.5-аас дээш оноо авах хэрэгтэй.

Тэтгэлгийн хамгийн гол шалгуур нь үйл ажиллагааны хөтөлбөр. Уг хөтөлбөр нь Австралид суралцах зорилго болон суралцах салбар, курсээ тодорхойлж, Австралид тухайн курсэд суралцсанаар таны одоогийн хийж байгаа ажил байгууллагын үйл ажиллагааг хэрхэн сайжруулах вэ? байгууллагын хөгжлийн зорилт, зорилгот яагаад нийцэж байгааг тайлбарласан эсээ юм. Таны үйл ажиллагааны хөтөлбөрийг аль хэр хэмжигдэхүйц, биелэгдэхүйц байна вэ, практикт хэр бодитойгоор нэвтрэх вэ? гэдгээр нь дүгнэдэг.

Ингээд хэрвээ таны өргөдөл шалгарвал, англи хэлийг жилийн хугацаанд эрчимтэй сурч шаардагдах оноо авах ёстой. Гэхдээ Австрали руу явах эцсийн шалгаруулалт нь таны суралцах салбар, курс, үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр шийдэгддэг учраас анхнаасаа зорилгоо зөв тодорхойлж, суралцах курс, салбараа зөв сонгон, үйл ажиллагааны хөтөлбөрөө сайн бичих хэрэгтэй.

Тэтгэлгийн шалгаруулалтыг Монгол дахь CaBSAF буюу Чадавхийг бэхжүүлэх, жижиг үйл ажиллагааг дэмжих Монгол-Австралийн зорилтот хөтөлбөрийн газар ([www.cabsaf.mn](http://www.cabsaf.mn)) зохион байгуулж явуулдаг юм.

ALA

ADS тэтгэлэгтэй харьцуулахад маш өндөр шаардлага тавьдаг. Тэтгэлгийн зорилго нь бус нутгийн харилцаа, хөгжилд хувь нэмрээ оруулах манлайлагчийг бэлтгэхэд оршдог. Магистр, докторын зэрэгт суралцуулдаг. Хүсэлт гаргагч наад зах нь бакалаврын зэрэгтэй байх бөгөөд бакалавраас дээш зэрэг эзэмшсэн байж болно. Өмнөх сургуулиа амжилттай, сайнаас дээш дүнтэй төгссөн байвал сайн, англи хэлний өндөр түвшний мэдлэгтэй (дор хаяж IELTS 6.5) байх зэрэг шаардлага тавьдаг. Суралцах курсийн хувьд бүх чиглэлийг хүлээн зөвшөөрдөг бөгөөд олон улсын худалдаа, өвчин судлал (pandemics), security, цаг агаарын өөрчлөлт (climate change including clean energy) чиглэлийг илүү дэмждэг. Шалгаруулалтын хувьд Та монголдоо бус, харин Ази, Номхон далайн бусад орны хүмүүстэй өрсөлддөг. Өргөдлийг бичгээр болон интэрнэтээр бөглөж болно. Бичгээр бол Монгол дахь CaBSAF-д хүргэж өгч болно, интэрнэтээр бол и-мэйлээр илгээхээс гадна, [www.USAID.gov.au](http://www.USAID.gov.au) хаягаар орж онлайнор бөглөж болно.

Эцэст нь хэлэхэд, Монгол Улсын иргэн төдийгүй, Австрали Улсын иргэд ч тэтгэлэг олоод өндөр төлбөртэй топ сургуулиудад сурах нь туйлын их аз завшаан. Австрали хүмүүсийн ихэнх нь дунд сургуулиа төгсөөд ажиллаж эхэлдэг. Хэдэн жилийн дараа зээлээр төлбөрөө хийгээд сурдаг. Харин Монгол хүн танд Австралийн Засгийн газар боломж олгож байна. Сургалтын төлбөр жилд дунджаар 18 мянган австрали доллар, дээр нь австралид амьдрах өртөг сарын дунджаар 1400 австрали доллар, эрүүл мэндийн даатгал, Монголоос ирж, очих зардал гээд тоолж баршгүй их мөнгийг та Монголд ч, гадаадад ч яаж ч хөдөлмөрлөөд олохгүй. Харин танд боломж байна. Боломжийг ашиглахгүй өнгөрвөл Таныг амьдралын зорилгогүй, идэвхгүй нэгэн байна гэж дүгнэнэ.

**МОНГОЛ-АВСТРАЛИ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХӨГЖЛИЙН  
ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД АВСТРАЛИ УЛСАД  
МАГИСТРИЙН СУРГАЛТЫН ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨРТ ХАМРУУЛАХ  
СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД ДАРААХЬ ШААРДЛАГЫГ  
ХАНГАСАН БАЙНА**

- ◆ Монгол Улсын иргэн бөгөөд байнга оршин суух эрхтэй байх
- ◆ Хүсэлт гаргахаас өмнөх нэг жилийн хугацаанд Австралийн Засгийн газрын аль нэг тэтгэлэгт хамрагдаагүй байх
- ◆ Одоо ажиллаж байгаа байгууллагадаа доод тал нь 2 жил тасралтгүй ажилласан байх
- ◆ Австралийн их, дээд сургуульд хүлээн зөвшөөрөхүйц боловсролын байгууллагаас бакалаврын зэрэг авсан байх./Монголын магадлан итгэмжлэгдсэн боловсролын байгууллагын олгосон гэрчилгээ, хавсралтын хамт/
- ◆ Эрүүл мэндийн болон Австралийн визний шаардлагыг хангах
- ◆ Сургалтын дараа холбогдох байгууллагадаа доод тал нь 2 жил ажиллах
- ◆ Байгууллагын удирдлагаас зөвшөөрөгдсөн байх
- ◆ IELTS-ийн 5 буюу түүнээс дээш оноотой тэнцэхүйц англи хэлний мэдлэгтэй байх
- ◆ Суралцах үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг /англи, монгол хэл дээр/ бичих, компьютерийн word програм, интернэт ашиглах хуудсыг бөглөх зэргийг багтаасан мэдүүлгийн хуудсыг бэлдэж өгөх

Сонгон шалгаруулалтад амжилттай оролцогчид Австралийн их, дээд сургуульд суралцах англи хэлний шалгуур үзүүлэлт болох IELTS-ийн 6,5 оноог хангахын тулд Монголд англи хэлний сургалтад хамрагдах боломжтой.

Холбогдох мэдээллийг [www.masp.mn](http://www.masp.mn) хаягаар орж үзнэ үү.